



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2019 оны 05 сарын 07 өдөр

Дугаар 189

Улаанбаатар хот

“Хөдөө аж ахуйн бирж”  
хязгаарлагдмал хариуцлагатай компанийн  
2018 оны үйл ажиллагаа, эдийн засгийн  
үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний болон  
контрактын биелэлтийн тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх  
хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, “Төрийн өмчит  
үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх  
журам” -ын 3.1, 3.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Хөдөө аж ахуйн бирж” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2018 оны  
үйл ажиллагаа, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний болон гүйцэтгэх  
захирал Х.Баатартай байгуулсан 2018 оны контрактын биелэлтийг “Сайн” гэж  
дүгнэсүгэй.

2.Компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний биелэлтэд  
хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т  
даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТУР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД